

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2026 ОНЫ 05 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХӨГЖЛИЙН
ДЭД ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХӨГЖЛИЙН ДЭД ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2026 оны 05 дугаар сарын 05-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4 – 32

1.	<i>“Аялал жуулчлалын салбарт тулгамдаж буй асуудал, шийдэл” Монголын аялал жуулчлалын мэргэжлийн холбоодын зөвлөл төрийн бус байгууллагын мэдээллийг сонсох</i>	4 – 22
2.	<i>Аялал жуулчлалын салбарыг дэмжихэд чиглэсэн хөнгөлөлттэй зээлийн талаарх Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын мэдээллийг сонсох</i>	22 – 32

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Аялал жуулчлалын хөгжлийн дэд хорооны 05 дугаар сарын 05-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Аялал жуулчлалын хөгжлийн дэд хорооны дарга Н.Батсүмбэрэл ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 6 гишүүнээс 4 гишүүн хүрэлцэн ирж, 66.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 18 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

***Нэг. “Аялал жуулчлалын салбарт тулгамдаж буй асуудал, шийдэл”
Монголын аялал жуулчлалын мэргэжлийн холбоодын зөвлөл төрийн бус байгууллагын мэдээллийг сонсох***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монголын аялал жуулчлалын мэргэжлийн холбоодын зөвлөлийн тэргүүн Н.Эрдэнэбат, Монголын аялал жуулчлалын мэргэжлийн холбоодын гүйцэтгэх захирал Н.Батцэнгэл, Монголын амьтан хамгаалах нийгэмлэгийн тэргүүн, Монголын аялал жуулчлалын мэргэжлийн холбоодын зөвлөлийн удирдах зөвлөлийн гишүүн С.Дамдинсүрэн, Монголын аялал жуулчлалын мэргэжлийн холбоодын зөвлөлийн удирдах зөвлөлийн зөвлөх, Өвөрхангай аймгийн Аялал жуулчлалын холбоодын удирдах зөвлөлийн гишүүн Ш.Батсугар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Т.Билэг-Өрнөх нар байлцав.

Мэдээллийг Монголын аялал жуулчлалын мэргэжлийн холбоодын зөвлөлийн тэргүүн Н.Эрдэнэбат танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Р.Батболдын тавьсан асуултад Монголын аялал жуулчлалын мэргэжлийн холбоодын зөвлөлийн тэргүүн Н.Эрдэнэбат, Монголын аялал жуулчлалын мэргэжлийн холбоодын гүйцэтгэх захирал Н.Батцэнгэл, Монголын амьтан хамгаалах нийгэмлэгийн тэргүүн, Монголын аялал жуулчлалын мэргэжлийн холбоодын зөвлөлийн удирдах зөвлөлийн гишүүн С.Дамдинсүрэн нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд “Аялал жуулчлалын салбарт тулгамдаж буй асуудал, шийдэл” Монголын аялал жуулчлалын мэргэжлийн холбоодын зөвлөл төрийн бус байгууллагын мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 11 цаг 00 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Аялал жуулчлалын салбарыг дэмжихэд чиглэсэн хөнгөлөлттэй зээлийн талаарх Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын мэдээллийг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газрын дарга В.Батчимэг, мөн газрын мэргэжилтэн М.Гантулга нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Т.Билэг-Өрнөх нар байлцав.

Мэдээллийг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газрын дарга В.Батчимэг танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд, Р.Батболд, Н.Батсүмбэрэл нарын тавьсан асуултад Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газрын дарга В.Батчимэг хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд, Л.Соронзонболд нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Аялал жуулчлалын салбарыг дэмжихэд чиглэсэн хөнгөлөлттэй зээлийн талаарх Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 11 цаг 24 минутад хэлэлцэж дуусав.

Дэд хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 07 минут үргэлжилж, 6 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 100 хувийн ирцтэйгээр 11 цаг 25 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХӨГЖЛИЙН
ДЭД ХОРООНЫ ДАРГА

Н.БАТСҮМБЭРЭЛ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ГАЗРЫН
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 05 дугаар сарын 05-ны өдөр, Мягмар гараг
Төрийн ордны “ҮНДСЭН ХУУЛЬ” танхим
10 цаг 18 минут

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХӨГЖЛИЙН ДЭД ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Н.Батсүмбэрэл: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Аялал жуулчлалын хөгжлийн дэд хорооны бүрэлдэхүүнд байдаг гишүүд Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд, Н.Батсүмбэр, Г.Лувсанжамц, М.Энхцэцэг нар ирж дэд хорооны хурлын ирц 66.7 хувиар бүрдсэн байна.

Хуралдааны ирцийг танилцуулж дууслаа. /алх цохив/

Мөн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд оролцож байна.

Дэд хорооны өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

— **Нэгдүгээрт**, “Аялал жуулчлалын салбарт тулгамдаж буй асуудал, шийдэл” Монголын аялал жуулчлалын мэргэжлийн холбоодын зөвлөл төрийн бус байгууллагын мэдээллийг сонсоно.

— **Хоёрдугаарт**, Аялал жуулчлалын салбарыг дэмжихэд чиглэсэн хөнгөлөлттэй зээлийн талаарх Соёл, спорт, аялал жуулчлалын сайдын мэдээллийг сонсоно.

Энэ хоёр асуудлыг хэлэлцэнэ. Хэлэлцэх асуудалтай холбоотой өөр саналтай гишүүн. Хэлэлцэх асуудлыг баталлаа. /алх цохив/

Хэлэлцэх асуудалдаа оръё.

**Нэг. “Аялал жуулчлалын салбарт тулгамдаж буй асуудал, шийдэл”
Монголын аялал жуулчлалын мэргэжлийн холбоодын зөвлөл
төрийн бус байгууллагын мэдээллийг сонсох**

Хэлэлцэх асуудлын эхний асуудал. “Аялал жуулчлалын салбарын тулгамдаж буй асуудал, шийдэл” мэдээллийг Монголын аялал жуулчлалын мэргэжлийн холбоодын зөвлөлийн төрийн бус байгууллагын мэдээллийг сонсоно.

Мэдээллийг Монголын аялал жуулчлалын холбоодын зөвлөл төрийн бус байгууллагын тэргүүн Н.Эрдэнэбат танилцуулна.

Таныг индэрт урьж байна. Индрийн микрофоныг нээе.

Н.Эрдэнэбат: Эрхэм гишүүдийн энэ өглөөний амар амгаланг айлтгая.

Монголын аялал жуулчлалын мэргэжлийн холбоодын зөвлөлийн тэргүүн Н.Эрдэнэбат.

Өнөөдөр Улсын Их Хурлын дэргэдэх Аялал жуулчлалын хөгжлийн дэд хорооны гишүүдэд аялал жуулчлалын мэргэжлийн холбооны зөвлөл, түүний хийсэн ажил, тэгээд бидэнд тулгамдаад байгаа үндсэн гол асуудал, зангилаа асуудлын талаар мэдээлэл өгөхөөр хүрэлцэн ирлээ.

Монголын аялал жуулчлалын мэргэжлийн холбоодын зөвлөлийг байгуулах болсон шалтгаан бол 2000 оны эхээр иргэний нийгмийн байгууллагууд хүчтэй болж, тухайн салбаруудад төрийн бус байгууллагууд эрх ашгаа хамгаалах зөвлөлүүд олноор байгуулагдсаны дараагаас эргээд энэ олныг эргүүлээд нэгтгэх, төртэй харьцах нэг сувагтай болох ийм тодорхой нөхцөлүүд үүссэн.

Би өөрөө Монголын аялал жуулчлалын холбоог удирдаж байсан. Энэ үед аялал жуулчлалын холбоо гишүүдтэй.

- ▶ Тур оператор,
- ▶ жуулчны бааз,
- ▶ зочид буудал –

-гэсэн ийм гишүүдтэй ийм холбоо нөгөө холбоодуудаа нэгтгэх боломжгүй байсан.

Яагаад гэвэл нөгөө холбоодуудаа нэгтгэхээр нөгөө холбоо нь 10, 20 гишүүнтэй жуулчны баазуудын холбоо, тур операторуудын холбоод нь гишүүдтэй.

Тэгэхээр аялал жуулчлалын холбоонд ороход хоёр асуудал гараад ирсэн. Гишүүнээр элсэхээр аялал жуулчлалын холбооны хувьд эдийн засгийн асуудал гараад ирсэн. Өвөрхангай аймгийн аялал жуулчлалын холбоо гэхэд 10 гишүүнтэй, тэгэнгүүт аялал жуулчлалын холбоонд гишүүнээр элсвэл нэг л татвар төлөх гээд байдаг. Тэр 10 гишүүнийг нь би авах юм бол 10 татвар авах гээд байдаг.

Тэгэхээр надад болохоор аль болох олон гишүүнтэй байх сонирхолтой. Холбоод нь болохоор зэрэг нэг л татвар төлөөд мэдээлэл авах сонирхолтой.

Гэтэл энэ нь хуулиар зохицуулагддаггүй. Дүрмээр зохицуулах дээр хэцүү байсан учраас аялал жуулчлалын мэргэжлийн холбоодын зөвлөлийг байгуулаад тухайн салбартаа ажиллаж байгаа мэргэжлийн холбоодоо нэгтгэх энэ ажиллагааг 2013 оноос эхэлж явуулаад өнөөдрийг хүрсэн.

Манай Монголын аялал жуулчлалын мэргэжлийн холбооны зөвлөлд –

- Монголын зочид буудлын холбоо,
- Зочлох үйлчилгээний холбоо,
- Гэр баазуудын холбоо,
- Guest house-ын холбоо,
- Тур оператор,
- Тур агентын холбоо,
- Аймгуудын аялал жуулчлалын холбоод,
- Тусгай мэргэжлийн тээвэрчдийн холбоо –

-гээд яг аялал жуулчдад голлох үйлчилгээ үзүүлдэг, гол асуудлыг шийддэг мэргэжлийн холбоод нэгдээд үйл ажиллагаагаа явуулж байгаа.

Гэтэл Зочид буудлын холбоо бол манай өнөө үндсэн гол сегментийн нэг. Монголд ирж байгаа жуулчдын хамгийн эхний буудлага цэг, нүүр царай болсон ийм ажил руу явж байна.

Зочлох үйлчилгээний холбоо байгаа. Энэ бол яг орж ирж байгаа гадна, дотнын жуулчин, зочдод хамгийн эхэнд үйлчилгээ үзүүлдэг үйлчилгээний ажилтнуудын холбоо,

Монголын Guest house-уудын холбоо. Монголын guest house-ууд. Бид сүүлийн үед томъёолохдоо “дэн буудал” гэж байгаа.

Улаанбаатар хотод 486, аймгуудад олноор байгуулсан дэн буудлуудын холбоод үйл ажиллагаа явуулж байгаа.

Аймгуудын аялал жуулчлалын холбоод. Манайд голлох Өмнөговь, Архангай, Өвөрхангай, Булган, Хэнтий, Баянхонгор гээд гол аялал жуулчлалын аймгуудын холбоод, түүн дотор өөрсдийнхөө хийх төлөвлөсөн ажлуудаа холбоондоо танилцуулаад, бид нараар дамжуулаад төр засагтаа санал болгоод явдаг ийм ажил байгаа.

Дээрээс нь манай мэргэжлийн холбоод нийлээд дотоод гадаадын үзэсгэлэнг зохион байгуулдаг.

Та бүхний сайн мэдэх Мишээлд болдог аялал жуулчлалын үзэсгэлэнг 2000 онд бид анх санаачилж байгуулсан. Зохион байгуулж байсан. Өнөөдөр дэлхийн жишигт хүрсэн бүс нутгийн чанартай ийм аялал жуулчлалын үзэсгэлэн болсон.

Монголын аялал жуулчлалын бүх бүтээгдэхүүн үйлчилгээ нэг дор цуглардаг. Төр, хувийн хэвшлийн түншлэл цогцоороо бүрдсэн ийм үзэсгэлэн байгаа.

Мөн бид олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнгүүдэд оролцдог. Гишүүдээрээ дамжуулж. Энд дэлхийн гол 3 үзэсгэлэн байгаа.

Энэ нь **ITB** (Internationale Tourismus-Börse) буюу Европын Германы Берлин хотноо зохион байгуулдаг дэлхийн нэг номерын үзэсгэлэн.

Нөгөөдөх нь **WTM** (World Travel Market) буюу Лондон хотноо болдог дэлхийн хамгийн анхны аялал жуулчлалын үзэсгэлэн.

Нөгөөдөх нь болохоор Азийн нэлээн гол үзэсгэлэн буюу **JATA** [Japan Association of Travel Agents] **Travel Fair** гэдэг үзэсгэлэн.

Энэ 3 үзэсгэлэнд бол 1994 оноос эхлээд Монгол Улс тасралтгүй төр засагтайгаа хамтраад хувийн хэвшилтэйгээ хамтраад оролцож эхэлсэн.

Үүгээрээ Монгол Улсын нүүр царайг тухайн бүс нутгууд төдийгүй дэлхийд сурталчилж явж ирсэн.

Одоо бидний өмнө тулгамдаад байгаа нэг асуудал бол дотоодын аялал жуулчлалынхаа үзэсгэлэнгүүдээ нэгтгэж гаднынхны жишгээр энэ ITB, WTM шиг нэг том үзэсгэлэн болгох ийм гол зорилт тулгараад байна.

Жишээлэх юм бол KOTFA Улаанбаатар хотын зохион байгуулдаг аялал жуулчлалын үзэсгэлэн, Монголын аялал жуулчлалын холбооны зохион байгуулдаг үзэсгэлэнгүүд гээд хоёр, гурван үзэсгэлэн цаг хугацааны хувьд зөрүүтэй ингэж яваад байгаа. Үүнийг тодорхой нэг цаг хугацаанд улс орны хэмжээний нэг цогц бодлогоор төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд нэг цонхоор, нэг бодлогоор гадагшаа ч, дотогшоо ч аялал жуулчлалаар сурталчлах ийм шаардлага гарч ирж байгаа.

Үүгээрээ бид аялал жуулчлалын оролцогчдыг үргүй зардлаас хамгаалах, үр бүтээлтэй, үр дүнтэй үйл ажилд тодорхой хугацаанд оруулах ийм чиглэл энд гарч ирж байгаа юм. Гарах үр дүнгээр энэ нь харагдаж байгаа.

Мөн аялал жуулчлалын мэргэжлийн холбоод гишүүн байгууллагуудтайгаа хамтарч зохион байгуулдаг үндсэн 3 том эвент байдаг. Энэ нь Хөвсгөл аймагт зохион байгуулдаг “Мөсний баяр”, Баян-Өлгий аймагт зохион байгуулдаг “Бүргэдийн баяр”.

Баян-Өлгий аймгийн тэр “Бүргэдийн баяр”-ыг бид Улаанбаатар хотод Жаргалантын аманд 3 дугаар сард зохион байгуулж байгаа.

Мөн Өмнөговь аймагт зохион байгуулдаг “Түмэн тэмээний баяр” гэж.

Одоо энэ “Түмэн тэмээний баяр” бол салбарлаад манай тэмээтэй аймаг болгон тэмээний баяраа зохион байгуулдаг.

Мөн нэг том юм нь 7 дугаар сард зохион байгуулагддаг “Дээлтэй Монгол” наадам.

Энэ наадмаар бид “Дээлтэй Монгол” парадаа жагсаадаг. Одоо сүүлийн үед манай бүх эвент арга хэмжээнүүд, манай салбарын төдийгүй бусад салбарын эвент арга хэмжээнүүд эхлэхдээ “Дээлтэй Монгол”-ынхоо парадаар эхэлдэг ийм ёс заншил тогтсон байна. Энэ бол “Дээлтэй Монгол” наадмыг манай салбар анх санаачилж өргөжүүлсний үр дүн ингэж харагдаж байна.

Бид мөн харилцагч байгууллагын гишүүдийнхээ юугаар агаарын тээвэрт хамтран ажилладаг.

Н.Батсүмбэрэл: Н.Эрдэнэбат гуай Та санаа зоволтгүй. Өөрийнхөөрөө гол юмнуудаа сайн танилцуулаад яв. Дахиад танд 5 минут сунгая.

Их Хурлын гишүүдэд ойлголтоо өгөхийн тулд та яаралгүй дахиад 5 минут байгаа гээд бодчих. Би сунгаж өгье.

Н.Эрдэнэбат: Баярлалаа. Тэгвэл ерөөсөө шууд тулгамдсан асуудал руугаа орёе.

Жуулчны тээврийн стандарт гэж. Энэ уг гарал нь юунаас болсон бэ гэхээр 2010-аад оны үеэр манайх аялал жуулчлалдаа дэвшил гаргасан. Тэр нь юу юм гэх дээр хуучны фургоныг өөрчлөөд Delica гэдэг буруу талдаа рультэй, тэгсэн хэрнээ эйр кондишнтай нэлээн комфорт сайтай ийм юм оруулж ирэнгүүт манай замын хөдөлгөөний дүрэмтэй зөрчилдсөн.

Энэ дээр хуучин фуриноор үйл ажиллагаа явуулдаг компаниуд шинээр энэ шинэ машин оруулж ирсэн нь зөрчил үүсээд тэрийгээ яахын тулд буруу талдаа тээврийн рультэй тээврийн хэрэгслийг хориглох гэдэг нэг стандарт гаргаад, дээрээс нь жуулчин тээврийн стандарт гээд энэ заавал зөв рультэй байна. Өнөө Монгол Улсынхаа хуульд нь тааруулаад. Тэгээд “жуулчин” гэсэн наалттай байна гэдэг журам гаргасан.

Гэтэл өнөөдөр энэ эсрэгээрээ Үндсэн хуулийн заалтад харшлаад эхэлж байна. Яагаад гэвэл гаднын жуулчин хүн монгол жуулчин хүн биш юм уу гэдэг болчхож байна. Яагаад гэвэл энэ турист жуулчин наалтыг гадаадаас жуулчин авдаг компаниуд жуулчныхаа машинд тодорхой хэмжээний шалгалт өгч байж үүнийг нааж байгаа.

Гэтэл өнөөдөр жирийн монгол хүн гаднаас ерөөсөө 2 найзаа аваад гарах гэх юм бол энэ байхгүй бол гадагшаа явахгүй. Орон нутгаар аялах эрх байхгүй. Ийм сөрөг юм гарсан.

Дээрээс нь нэгэнт Монгол Улсад жолооны курсээр жолооч бэлдэж байгаа. Тэгээд энэ чинь өөрөө 3, 4 ангилалтай. Тийм ээ. Тэдэн жил “В” ангилалтай бол ингэнэ, “С”, “D” бол ингэнэ. Энэ чинь олон жил тогтсон Монгол Улс чинь өнө эртний түүхтэй, тодорхой хэмжээний авто тээврийн хөгжилтэй, 100 жилийн хөгжилтэй энэ улс орон ямар шинээр авто тээвэр хөгжүүлж байгаа биш. Бүх юм нь цэгцэрсэн байж байхад дээрээс нь нэг жуулчин тээвэр гээд ерөнхийдөө шалгалт авдаг, мөнгө авдаг, нэг наалт өгдөг л ийм юм болсон. Үүнийг цуцлах шаардлагатай гэж. Үүнийг манай эрхэм гишүүд зөвөөр ойлгоорой гээд.

Гэтэл дээрээс нь 2011, 2012 оноос эхлээд мэргэшсэн жолоочийн сургалт, мэргэшсэн жолоочийн үнэмлэх гэдэг юм гараад ирсэн.

Одоо 150 мянган төлбөртэй хэвээрээ юу. Тийм ээ. 3 хоногийн сургалт хийгээд 150 мянган төлбөр төлөөд мэргэшсэн жолоочийн үнэмлэх өгдөг. Жолоочийн үнэмлэхээс гадна тусдаа. Энэ байхгүй бол бас жуулчинтай постуудаар гардаггүй болсон.

Ингээд бид өөрөө өөрснөө нэг талаар ингээд аялал жуулчлалаа хөгжүүлнэ, эдийн засгийн валютын орлого оруулна гээд байгаа хэрнээ яг тэрэндээ ажилладаг нөгөө орчуулагч, жолооч нар ийм асуудлаар чөдөр тушаа болоод яг жуулчны улирал эхлэхээр л 22-ын товчоон дээр баахан хэрүүл болдог.

Тэгээд сайд дарга болонгуутаа бөөн зарга болоод, сошиалаар зарга болдог. Түр зогсоодог, хойшлуулдаг. Үүнийг нэгмөсөн цуцалмаар байна гэсэн нэг санаа.

Энэ мөн ч олон жил ярилаа даа. Энэ үйлчилгээний цогцолбор гээд. Манай эрхэм гишүүд мэдэж байгаа байх. Манайхаас өөр газар 100 километр тутамд л гаднын авто колонкууд нь байх юм. Хажууд нь дэлгүүр нь байх юм. Тэгээд дундаа эрэгтэй, эмэгтэй тав, арван нольтой байх юм. Ингээд шийдсэн байх юм.

Бид үүнийг ерөөсөө шийдэж чадахгүй. 0 байхгүй. 100 жил болж байхад модон жорлонтой гээд. Та нар мэдэж байгаа байх. Элсэн тасархай хавиар чинь гэрүүд нь замынхаа хойд талд, нолиуд нь замынхаа урд талд. Тэгээд хоолоо идчихээд бие засахаар заавал замаа хөндлөн гарах болдог.

Тэгээд гаднын жуулчид бүр гайхаад байна. Энэ чинь ямар зохион байгуулалттайтай юм бэ гэдэг. Ийм шившгийн юмыг сүүлийн үед манай энэ CU, GS25 нээгдээд энэ бол арай өөр болж байна.

Дээрээс нь манай яаман дээр яригдаж байна. Сая манай шинэ сайд хэлж байна лээ. Одоо энэ колонкуудад тодорхой хэмжээний юу өгөөд энэ колонкуудыг нольтой болгоё л гэж.

Тэгэхээр манайх эхний ээлжид Элсэн тасархай хавьд нэг сайн колонк, тийм супермаркеттай, тэгээд нольтой, зогсоолтой, шүршүүртэй нэг ийм нефтийн компаниудтайгаа ярьж байгаад нэг жишиг нэгийг хийгээд тэр ийм юм цаашаагаа хуульчлаад явах юм бол дэлхийн жишгээр явах бололцоотой.

Энэ дээр эрхэм гишүүд анхаарлаа хандуулах юм бол бид нэг модон жорлон, энэ нэг нолийн асуудлаас нэг салах ийм бодолтой.

Тэгээд энэ нэг санал солилцох асуудлаа яахын тулд би Та бүхэнтэйгээ уулзахын тулд энэ аялал жуулчлалынхаа юмнуудыг харж байтал манай Засгийн газрын 2024, 2028 оны мөрийн хөтөлбөр байна. Бид нийт юмнууд ингээд хэрэгжээд явж байгаа.

Тэгээд энэ виз гээд л энэ бүх юмнууд гээд бид өөрсдийнхөө бололцоогоор хамтран ажиллаад явж байдаг.

Гэтэл энд нэг сонин юм байгаа.

Одоо дэлхийд байхгүй нэг юм орсон явах юм. Энэ “аялал жуулчлалын чөлөөт бүс” гэж ийм юм хаана ч байхгүй. Дэлхийд байхгүй. Яагаад гэвэл “эдийн засгийн чөлөөт бүс” л гэж байгаа. Тэр чөлөөт бүс дээр л аялал жуулчлалын юм байх ёстой биз дээ. Тэгээд аялал жуулчлалын чөлөөт бүс гээд.

Дээрээс нь Д.Оюунхорол сайдын үед аялал жуулчлалын чөлөөт бүс гээд 200 сая төгрөг тавина гээд ажлын хэсэг гарч байгаад тэгээд зогссон юм байгаа. Тэгтэл энэ яаж яваад ийшээ орсон юм. Аялал жуулчлалын чөлөөт бүс байгуулна гээд.

Тэгээд манай Их Хурлын гишүүд үүнийг мэдэж байгаа байх. Тийм ээ. Дэлхийд гэвэл эдийн засгийн чөлөөт бүс гээд л аль болох нөгөө татваргүй бараа, аль болох л хүмүүс бизнес хийх боломжийг нь олгодог бүс л гэж бид ойлгодог.

Гэтэл аялал жуулчлалын чөлөөт бүс гээд орсон нэг юм явж байна. Үүнийг би Та бүхэнд хуулийн улсууд учраас дурдъя гэж бодсон.

Тэгээд аялал жуулчлалын хууль 2000 онд анх батлагдсанаасаа хойш 4, 5 удаагийн өөрчлөлт ороод хамгийн сүүлд 2023 оны 05 дугаар сарын 04-нд сүүлчийн өөрчлөлт нь орсон. Энэ дээр бас нэг ажлын хэсгийнх нь улсууд болохоор манайхнаас жоохон хууль тогтоомжийн талаар жоохон мэдлэг муутай улсууд, урьд нь хуулийн тийм ажлын хэсэг дээр ажиллаж байгаагүй улсууд орсноос болов уу яав гэхээр нэг жоохон тийм амьдралгүй хэд хэдэн заалт энд оржээ.

Жишээлэх юм бол Та бүхэн энэ 10 дугаар зүйлийг харж байна. Жуулчны хөтөч, тайлбарлагч гэж. Тэгээд дотор нь уншихаар тэр хүнээс шалгалт авна, зэрэг олгоно, тэгээд энгэрийн тэмдэг зүүнэ. Ингээд хэлчхэж байгаа юм.

Гэтэл манай хөтөч, тайлбарлагч нар дотроос үндсэн ажилтан хүн байхгүй. Дандаа улирлын чанартай. Ихэвчлэн энд тэндхийн гадаад харилцааны салбарт ажилладаг гадаад хэлний сургуулиудад багшилдаг. Зундаа 7, 8 сард л аялал жуулчлалын компаниудаар ажилладаг ийм улсууд байдаг. Үүнийг 1998 онд бүгдийг нь намайг Аялал жуулчлалын холбооны Ерөнхийлөгч байхад зэрэг олгоод баахан шалгалт авсан.

Гэтэл нэгдүгээр зэрэгтэй нөгөө улсууд нь компаниуд дээр очихоор авдаггүй. Яагаад гэвэл компаниуд чинь бизнес хийж байгаа учраас дандаа өөрийнхөө мэддэг, өөр дээрээ олон жил ажиллуулсан орчуулагчаа л авна. Танихгүй орчуулагчийг хэчнээн сайн хэлтэй байсан ч авахгүй.

Тэгэнгүүт над дээр ороод ирдэг. Яаман дээр яам над руу явуулдаг. Үгүй тэгээд би шалгадаг юм биз дээ. Нэгдүгээр зэрэгтэй англи хэлний орчуулагч байна. Танай компаниуд авахгүй байна.

Н.Батсүмбэрэл: Микрофонгүй яваад байдаг. Н.Эрдэнэбат гуай танд 2 минут нэмээд өгье. Тэгээд наад дотроо багтаад. Микрофоныг нээе. 2 минутаар.

Н.Эрдэнэбат: 26 дугаар зүйл байгаа. Тэр аялал жуулчлалын мэргэжлийн холбоо гээд.

Энэ уг нь анх 27.1 гээд явж байхдаа манайх шиг Аялал жуулчлалын мэргэжлийн нэгдсэн холбоо буюу Аялал жуулчлалын мэргэжлийн холбоодын зөвлөл гэсэн нэртэй явж байсан. Холбоодыг нэгтгэсэн холбоо байх ёстой. Мэргэжлийн нэгдсэн холбооны хуулийн дагуу. Тэгсэн чинь одоо буцаагаад яг нөгөө мэргэжлийн холбооны нэр өгөөд аялал жуулчлалын холбоог буцаагаад байгуулсан.

Тэгээд ахиад л нөгөө тур оператор, жуулчны бааз байж байгаа.

Тэгээд би мэргэжлийн, би мэргэжлийн бус гээд нөгөө хоёр холбооны хооронд маргаан үүссэн.

Гэтэл бид чинь хөгжил байна. Бид урагшаа явах ёстой. Бид нэгдэх ёстой. Нэг цонхоор төртэй харьцах ёстой учраас энэ заалтыг өөрчлөөч ээ гэдэг ийм юм явж байгаа.

Сурталчилгаан дээр бас ч гэж Л.Оюун-Эрдэнэ Ерөнхий сайдын нэг хийсэн ганц том юм бол Монголын аялал жуулчлалд энэ гадаад сурталчилгаанд хөрөнгө тавьж өгсөн явдал.

Бид бол 100 саяын хөрөнгөтэй байж байгаад л 500 мянган жуулчин авдаг байсан. Одоо чинь 6-аас 7 тэрбум төгрөгтэй бид 800 хэд рүү явлаа. Сая болгохын тулд энэ мөнгийг өшөө нэмэгдүүлэх ёстой шүү. Харин яг зөв зүйлд нь зарцуулж байна уу, яг сегментээ онож байна уу гэдэг дээр нь бид хяналт тавих ёстой. Хамтдаа.

Дээрээс нь жуулчны баазууд дээр ганц л юм байдаг юм. Бид олон жил ярилаа. Ерөөсөө л газрын асуудал байдаг юм. Жуулчны баазад газар өгсөн өгсөн бол ойр хавьд нь 10 километр газар өгөхгүй л байх ёстой. Тэгэх юм бол тэр жуулчны бааз жуулчны цогцолбор болтлоо хөгжинө. Тэгэхгүй нэг газар өгчхөөд хажууд нь жоохон юм олоод ирэхээр хажууд нь 3, 4 газар газар өгөхөөр бүгдээрээ дампуурч байгаа юм. Үүнийг би 20 жил ярьж байгаа. Яам ч сонсдог, засдаг. Тэгээд газраар хөнгөлдөг. Тэгээд л ахиад л нөгөө хэдэн бааз нь ингээд л явж байгаа. Үүнийг нэг хэлье гэж бодсон.

Зочид буудлын хувьд нөгөө үл хөдлөхийн татвар, энэ гадаадаас орж байгаа орлогыг НӨАТ-аас чөлөөлж өгөөч ээ гэдэг хүсэлтийг тавьсан. Манай зочид буудлын холбоо. Тур операторыг. Энэ нь бол ойлгомжтой.

Дээрээс нь би нэг хамгийн сүүлд энэ тусгай зориулалтын ан дээр. Н.Батсүмбэрэл дарга аа, манай энэ гавьяатад 2 минут өгч болох уу? Энэ тусгай зориулалтын ангийн дуудлага худалдааны талаар танилцуулга дээр нь.

Н.Батсүмбэрэл: Танилцуулга хийсэн Н.Эрдэнэбат танд баярлалаа. Та суудалдаа сууна уу.

Бид аялал жуулчлалын талаар мэдээллийг авъя гээд Аялал жуулчлалын хөгжлийн дэд хороо ер нь ойрхон сүүлийн гурван ч хурал хийлээ. Энд манай Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам их идэвхтэй санаачилж ажиллаж байгаа гэдгийг би энд дурдаж онцолж хэлье.

Мөн холбогдох яамд ч энэ талаар зохих арга хэмжээгээ авч ажиллаж байгаа.

Тэгээд бид өнөөдөр хоёр асуудал сонсож байгаагийн нэг дэх нь “Аялал жуулчлалын салбарт тулгамдаж буй асуудал, шийдэл” гэдэг сэдвээр Монголын аялал жуулчлал, жуулчлалын мэргэжлийн холбоодын зөвлөл төрийн бус байгууллагын мэдээллийг сонсож байгаа.

Энэ асуудалтай холбоотойгоор хэдүүлээ ажлын хэсгийг танилцуулъя. Та бүхэнд.

Ажлын хэсэгт Намсрайжавын Эрдэнэбат Монголын аялал жуулчлалын мэргэжлийн холбоодын зөвлөлийн тэргүүн, Намсрайжавын Батцэнгэл Монголын аялал жуулчлалын мэргэжлийн холбоодын гүйцэтгэх захирал, Содномжамцын

Дамдинсүрэн Монголын амьтан хамгаалах нийгэмлэгийн тэргүүн, Монголын аялал жуулчлалын мэргэжлийн холбоодын зөвлөлийн удирдах зөвлөлийн гишүүн, Шагдарын Батсугар Монголын аялал жуулчлалын мэргэжлийн холбоодын зөвлөлийн удирдах зөвлөлийн зөвлөх, Өвөрхангай аймгийн Аялал жуулчлалын холбоодын удирдах зөвлөлийн гишүүн гэсэн ажлын хэсгийн бүрэлдэхүүн байна.

Ингээд хэлэлцэх асуудалтай холбоотойгоор асуулт асуух гишүүд нэрээ өгье.

Л.Соронзонболд гишүүн асуух уу? Нэр авч дууслаа. Г.Лувсанжамц гишүүний микрофоныг нээе.

Г.Лувсанжамц: Мэргэжлийн холбооддоо, нэгдсэн холбоонд өдрийн мэнд хүргэе. Ийм дэлгэрэнгүй танилцуулга хийж байгаад баярлалаа.

Сая саналууд, шийдлүүдтэйгээ цуг явж байгаад баяртай байна.

Тэгээд бид бүхний хийж чадах ажил бол хууль, эрх зүйн орчин дээр өөрчлөлт оруулах. Тийм ээ.

Энэ дээр гэхдээ Засгийн газрын 4 жилийн мөрийн хөтөлбөр байгаа. Тийм ээ. Энэ дээр байгаа заалтуудыг өөрчлөхөөс илүүтэйгээр хэдүүлээ ард нь байгаа Аялал жуулчлалын тухай хууль, саяын таны хэлсэн жуулчны тээвэр стандарт, тэгээд нэг бааз байгуулах юм бол 10 километрээс илүү ойр орчимд нь дахиж байгуулахгүй ч юм уу. Тийм ээ. Ийм зүйл, заалтуудыг нь хуульд яаж тусгавал мэргэжлийн холбоо нь аж ахуйн нэгжүүддээ илүү зүгээр байна гэсэн тийм яг хуулийн гаргалгаатай шийдэл байвал зүгээр болов уу гэж бодож байгаа юм. Энэ хуулийн энэ зүйл, заалт гээд.

Тэгээд яагаад ингэж хэлж байгаа вэ гэхээр одоо Зөвшөөрлийн ерөнхий хууль гээд хэлэлцэж байгаа. Энд бас олон Л.Соронзонболд гишүүн, Р.Батболд гишүүн бид гурав гурвуулаа ажлын хэсэгт нь байгаа.

Тэгээд яг өглөө саяын жишээлбэл таны хэлсэн ан агнуур дуудлага худалдаа гээд тэгж байгаа шүү дээ. Тийм ээ? Тэр заалт дээр Р.Батболд гишүүн саналаа хэлж байсан байхгүй юу.

Хэрвээ та хэд маань мэдээж мэргэжлийн холбоо юм чинь хуульч бол байгаа байлгүй дээ. Тийм ээ? Өргөн барьсан хуулиуд нь бол d.parliament.mn дээр байгаа. Түүн дээр Аялал жуулчлалын тухай хууль ч байдаг юм уу, эсвэл Байгаль орчны хууль дээр байгаа энэ зүйл, заалтуудыг ингэж өөрчилмөөр байна гэсэн санал өгөх юм бол бид ажлын хэсэг дээрээ хүлээж аваад яаманд нь танилцуулаад нэгдсэн шийдэл гаргах боломжтой.

Тэгээд таны энэ хэлж байгаа шийдлүүдийг бол бүгдийг нь дэмжиж байгаа. Барилгын салбараар ч явах юм яг мэргэжлийн холбоо нь л энэ бүх зүйлээ хариуцаад явсан нь хамтдаа хөгжих боломж нь бүрддэг. Тийм ээ? Тэгээд аялал жуулчлалын салбар чинь яам нь Байгаль орчны яам, Аялал жуулчлалын яам гээд тусдаа салчаад. Дээрээс нь Зам, тээврийн яам нь үнэмлэхийнхээ асуудлыг яриад нэгддэггүй болохоор хувийн хэвшил, мэргэжлийн холбооноос нь ийм санал өгч байна гэх юм бол талдаа Засгийн газар яамдын саналуудыг нь нэгтгэхэд бид дэмжээд ажиллах боломжтой учраас таны хэлж байгаа зүйл, заалтуудын өөрчлөлтүүдийг бүрэн дэмжиж байна.

Тэгээд ялангуяа бичгээр саналууд байвал их зүгээр болов уу гэж бодож байна. Өнөөдөр ийм презентэйшн хэлбэрээр файлуудыг авлаа. Тийм ээ. Бичгээр яг хуулийн томъёоллоор нь би санал байвал бид шууд ажлын хэсэг дээрээ аваад хэлэлцээд явах бүрэн боломжтой байна. Санал хэллээ.

Н.Батсүмбэрэл: Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд.

Р.Батболд: Сая Г.Лувсанжамц гишүүн хэллээ. Бид зөвшөөрлийн ажлын хэсэг дээр ажиллаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр дөнгөж сая сонсож байсан юман дээр яг наад ан агнуурын асуудал ороод ирж байгаа юм. Зөвшөөрөл дээр.

Тэгээд дуудлага худалдаагаар яваад байхаар мэргэжлийн олон улсын холбоо байсан шүү дээ. **CITES**¹ (Convention on International Trade in Endangered Species of Wild Fauna and Flora). Тийм ээ.

CITES-тайгаа яаж зөрчилдөөд байгаа юм. Түүн дээр хэрвээ эрсдэлтэй байх юм бол ямар үр дагавар гарах юм бэ гэдгийг Та нар нэг яриад өгөөч гэж хэлэх гээд байгаа юм.

Тэгэхгүй бол ойлгохгүй байна. Зүгээр Байгаль орчны яаман дээр хэдэн ан агнуур зардаг. Хэдэн нөхдүүдийн үйл ажиллагааг хориглоод байгаа юм шиг мөртлөө цаагуураа явж байсан отог байгуулдаг, ан амьтнаа хамгаалдаг, тоолдог барьдаг үйл ажиллагаанууд чинь бүгд тасалдаад байгаа гэж би ойлгоод байгаа.

Тэрийг чинь ойлгохгүй байгаад байна. Тийм ээ. Энэ хууль тогтоох ч хууль боловсруулаад байгаа улсууд чинь өөрсдөө ойлгохгүй шүү дээ.

Тэгэхээр энэ дээр яамаар ч юм бэ дээ. Ан амьтантай холбоотой болоод ирэхээр Байгаль орчны яам руугаа ороод байдаг. Тэгсэн мөртлөө энэ чинь бас нэг хэлбэрийн аялал жуулчлалын салбар шүү дээ.

¹ Ховордсон зэрлэг амьтан, ургамлын олон улсын худалдааны тухай конвенц.

Тэгээд яаж үүнийгээ зохицуулах ёстой юм? Үүнийг манай Аялал жуулчлалын яам маань жоохон бодмоор байна. Хоёр талаасаа уулзаж байж тэр Зөвшөөрлийн хууль дээр яах ёстой юм.

Тэр CITES дээр ер нь одоо бид ингээд эрсдэлтэй юм уу, эсвэл тэр конвенцоос гарах ч гэдэг юм уу, хөөгдөх ч гэдэг юм уу, юу гэдэг юм. Тийм ээ. Нэг тиймэрхүү юм болвол Монгол Улс ямар юу хүлээх юм? Эрсдэл хүлээх юм. Тийм ээ. Ямар үр дагавартай юм? Үүнийг зүгээр яриад өгмөөр байгаа юм. Тэгэх үү? Тийм.

Н.Батсүмбэрэл: Индэр дээр нэмж хариулах юм байвал өндөр индэр лүү ойрхон сууж байгаад нэмээд хариулж болно шүү. Тэмдэглэлд үлдээх үүднээс нэрээ хэлээд тэгээд асуултад хариулаад явна.

Н.Эрдэнэбат: Энэ тусгай зориулалтын ан буюу спорт ан агнуур хэлэгддэг энэ төрөл дээр 3 жилийн өмнөөс дуудлага худалдааны систем орж ирснээс болоод энэ олон жил тогтсон ийм орвонгоороо эргээд Монголын дотоодын аяллын компани төдийгүй гадаад бид нарын харьцааны нэр хүнд эрсдэлд орж эхэлсэн.

Дээрээс нь сая Р.Батболд гишүүний хэлж байгаа тэр CITES буюу Ховор амьтдыг худалдаалах дэлхийн конвенцыг бид зөрчих ийм асуудал үүссэн. Тэр конвенцийн гол ач холбогдол нь юу юм гэхээр тухайн худалдаалж байгаа ховор амьтад яг зохих ёсоор тухайн орон нутагт хамгаалалтад байж байгаад зохих ёсоор тэр агнагдах ёстой зүй зохисоороо агнагдаж байна уу, үгүй юу гэдэгт хяналт тавьдаг ийм конвенц. Тэрэнд манай улс нэгдсэн явж байгаа.

Гэтэл дуудлага худалдаа гараад ирэх дээр тэр конвенц юу гэж үзэж байна гэхээр нөгөө хамтын нөхөрлөлийн менежментээр агнуурын бүс нутаг хариуцаад ингээд явж байсан юм руу нь дуудлага худалдаа оруулахаар тэр чинь хэн мөнгөтэй хүн нь аваад ангаа хийгээд эхлэхээр нөгөө байгаль орчныг нь хамгаалах, тэгээд зохистой ашиглах үндсэн зарчим алдагдаж байна гэж тэд нар үзэж байгаа.

Ингээд эд нар ямар арга хэмжээ авдаг вэ гэхээр манай яаманд хэд хэдэн анхааруулгаа өгсөн юм билээ. Хэрвээ тэгээд манайхаас ажлын хэсэг гараад Амьтны тухай хууль, тэр CITES-ын тухай хуульдаа өөрчлөлт оруулах гээд ажлын хэсэг гарсан явж байгаа юм билээ. Энэ нь юу гэхээр маш хурдан ингэж өөрчлөлтөө оруулахгүй, дуудлага худалдаагаа болиулахгүй бол CITES яадаг вэ гэхээр манайхаас гарахыг нь хориглодог. Тухайн улсуудад import license-ийг нь хориглодог.

Тэгэхээр бид энд анг нь хийлгэлээ ч гэсэн тухайн улсдаа явуулж чадахгүй ийм нөхцөл үүсдэг.

Тусгай зориулалтын ан нь өөрөө нэг өвөрмөц онцлогтой. Жилд хийгдэж байгаа гадаадын анчид ирж хийж байгаа ангийн 90 хувь нь зөвхөн Америкийн Нэгдсэн Улсад ногддог.

Тэгээд үүний урд манайд CITES дээрээ юмнууд яагаагүй болсноос болоод манайх агнуурын бүс гэж байгууллаагүй, менежментийг нь хариуцуулдаггүй байснаас болоод Америкийн Нэгдсэн Улс руу оруулах ангынх нь квотыг нь багасгаж байсан. Алтайн угалзыг нь 30 байсныг нь 5 болгоод, говийнхыг нь 3 болгоод тухайн жилд.

Энд ямар сөрөг юм гардаг вэ гэхээр эргээд нөгөө сумын төсвийн бараг тэн хагас нь энэ агнуураас орж байдаг.

Нэг угалзаас бид 24 мянган доллар буюу 80-аад сая төгрөг сумын төсөвт төвлөрүүлж байгаа шүү дээ.

Тэгээд зарим сум бол 2-оос 3 угалз агнуулдаг. Тэр нь 2010-аад оны үед бол сумынх нь төсөв тэр чигээрээ байдаг байсан. Одоо бол сумын төсвийн 30-аас 50 хувь гэж байгаа. Энэ төсөв нь байхгүй болдог. Гэтэл төсөв дээрээ тавьсан. Ингээд та нар ангаа хийгээч ээ гээд байдаг. Америк оруулахгүй юм чинь анчид ирэхгүй шүү дээ гээд. Ингээд энд хэдэн монгол хөдөө орон нутагт үл ойлголцлоор ийм нэг ноцтой юм яваад байдаг.

Тэгээд бид яам, Тамгын газраар ч гэсэн дуудлага худалдааг болиулаад хуучнаар нь ном журмаар нь явуулаач ээ. Тэр дуудлага худалдааны орлого нь алга болох эрсдэлтэй, дуудлага худалдаанаас ашиг олсон байна гэж байгаа бол улсад төлдөг тэр 24 мянган долларыг нь 40, 50 мянга болгодог юм уу. Тийм ээ. Хамгийн гол нь гадааддаа бид ер нь менежмент агнуурын мэргэжлийн бүс байна. Тэр бүсийн менежментийн төлөвлөгөө байна. Менежмент хэрэгжүүлэгч тэр нь ангаа хамгаалаад зохистой ашиглаж байна гэдгээ энэ CITES-ын хуулиараа харуулаад, дээрээс нь дуудлага худалдаа байхгүй учраас зохистой, агнах ёстой юмыг нь агнаад хуулийн дагуу бүх юм явагдаж байна гэдгээ бид харуулах ёстой.

Дээрээс нь энэ тусгай зориулалтын ан агнуур Монгол Улсад валютын орлого оруулдаг. Одоо жилд 10 орчим сая долларын орлого оруулж байгаа.

Гэтэл манайд нэг зовлонтой юм байдаг. Одоо жишээ нь агнуурын бүс нутгийн тэр бүсийг тодорхойлохдоо төрөөс эрх авдаг. 5 жилийн тусгай зөвшөөрөлтэй агнуур зохион байгуулалтын мэргэжлийн байгууллага тэр төлөвлөгөөг хийдэг.

Тэгээд тэр төлөвлөгөөг хийгээд тухайн бүс нутгаас тэдэн тонны ан агнах боломжтой гэсэн тоо гаргаад ирдэг. Уг нь тэр тоо нь л Засгийн газраар ороод л эцсийн тоо болж гараад л тэр хүмүүс тэр тоондоо агнуураа хийгээд л мөнгөө төлөөд явж байвал ямар ч асуудалгүй.

Гэтэл дуудлага худалдаанаас өмнө яагаад энэ асуудлаараа дуудлага худалдаа болсон бэ гэхээр тэр тухайн бүс дээр нь яах юм бол... /минут дуусав/

Н.Батсүмбэрэл: Хугацаа дууссан байна. С.Энхцэцэг гишүүн болсон байна. Л.Соронзонболд гишүүн асуух уу?

Тэгвэл ингэе. Өнөөдөр бидэнд мэдээлэл өгсөн Монголын аялал жуулчлалын мэргэжлийн холбоодын зөвлөл төрийн бус байгууллагын хамт олонд талархал илэрхийлье.

Энэ байгууллагын гаргаж байгаа асуудлууд тодорхой байна. Бид мэдээллийг авлаа. Хуулийн хэд хэдэн заалт дээр өөрчлөлт оруулах санал гаргаж байгаа юм байна.

Тэгээд үүнийг дэд хорооны бланк дээр бичиг бэлдээд холбогдох яамнаас санал авахаар хүргүүлье. Яам энэ дээр байр сууриа мэргэжлийн яам илэрхийлэх нь зөв.

Тэгээд 6 заалтыг хөндсөн байж байна. Бусад саяын яриад байгаа жуулчны баазын асуудал, зочид буудлын асуудал, тур операторын асуудал, тусгай зориулалтын ангийн асуудлыг ажлын шугамаар бид судалъя.

Тэгээд нэмээд энэ холбоо маань бидэнд нэмэлт мэдээллээ эдгээр асуудалтай холбоотой асуудлаар албан тоотоор ирүүлээч гэж хүсье.

Тэгээд Н.Эрдэнэбат тэргүүнээс гадна дагалдаж 3 хүн ирсэн байна. Энэ 3 хүн бидэнд мэдээллээ хуваалцацгаах гэж бодож байна.

3, 3 минут өөрийнхөө санаа бодлыг хуваалцах боломж олгоё. Тэгээд индэр дээр минутыг 3, 3 минутаар 3 хүнд нээж өгье.

Н.Батцэнгэл: Та бүхэндээ энэ өглөөний амгаланг айлтгая.

Миний өгөх мэдээлэл нэмэлтээр байгаа. Нэмэлт дотроо зочид буудлын бизнес эрхлэгч нартай холбогдолтой мэдээлэл өгье.

Нэгдүгээр асуудал нь юу гэхээр ажиллах хүчний хомсдолтой асуудалтай үүдээд өнөөдөр зочид буудлууд гадаадаас ажиллах хүчин оруулж ирж ажиллуулж байгаа. Үүнтэй холбогдуулаад гадаад ажилтан ажиллуулсны Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төлдөг төлбөрийн асуудал нэлээд өндөр байгаа.

Ер нь бодлогын яамаараа уламжлагдаад 50 хувийн хөнгөлөлт авч байгаа хэдий ч гэсэн тухайн 50 хувийн хөнгөлөлт нь буцаан олголт дээрээ хязгаарлагдмал байх ч юм уу, эсвэл олгогдож амжаагүй. Дээр нь Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар дээр хийгдэж байгаа процессууд их хүндрэлтэй байгаа учраас гадаадаас ажиллах хүчин дээр нэлээн анхаарал хандуулж өгч, энэ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төлөх төлбөрийг хөнгөвчлөх тал дээр бодох боломж байна уу гэж асууж байна.

Хоёрдугаарт нь, цагдаагийн байгууллагаас өгч байгаа тэр public registration гэдэг программ бий. Тэрийг олон улсын программтай буудлуудад заавал байрлуул гэдэг ийм шахалт гараад, сая төгрөгийн төлбөр аваад байгаа. Энэ асуудал орон нутгийг хамарсан асуудал болж байна.

Дараагийнх нь, энэ city tax. 1 хувь байж байхад нь бид тооцоо хийж үзэж байсан. Одоо 2 хувь болж байгаа учраас city tax-ын төлбөрийг аялал жуулчлалын салбарт зарцуулах боломжийг судалж өгөөч ээ гэж үзэж байгаа.

Гуравдугаарт нь, сайдын саяхны мэдээлэл дээр бид Солонгосын Засгийн газарт өөрсдөө 2016 онд төслөө боловсруулаад өгөөд салбарт ур чадварын төвийг байгуулсан. Яармагт байгаа.

Үүнийг мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв болгож болохгүй. Салбарын ур чадварын төв. Skills Center буюу салбарын ур чадварын төв болгоод өөрийнхөө салбарын үйлчилгээний байгууллагын ажилчдыг тасралтгүй хөгжүүлж үе шаттай сургалтыг явуулах нь зүйтэй болов уу гэсэн санал байна.

Дараагийн нэг юм нь одоо яг үйл ажиллагаа явуулж байгаа эрх зүйн орчны хүрээнд зарим нэг зөрчилтэй зүйлүүд гардаг. Үүнийг би албан бичгээр өгье.

COP17 гээд том арга хэмжээ байгаа. Түүнтэй холбогдуулаад зочид буудлуудыг тодорхой хэмжээнд блоклосон боловч өнөөдрийг хүртэл урьдчилгаа төлбөрийг төлж үүнийг баталгаажуулаагүй байгаа. UNDP-ээс зочид буудлуудыг сонгон шалгаруулна гэж нэг зар явчхаад буцаагаад сонгон шалгаруулалтыг хийхгүй гэсэн ийм зөрүүтэй мэдээллүүд яваад байгаа.

Тэгэхээр COP17-г зохион байгуулахтай холбогдуулаад зочид буудлуудыг албан ёс ёсоор хамтрагч байгууллагыг нь дахин нэг харж үзэх хэрэгтэй болов уу гэсэн ийм тодотгол байна.

Сонссонд маш их баярлалаа. Бусад мэдээллүүдийг албан бичгээр өгөх болно.

Н.Батсүмбэрэл: Микрофоныг нээе.

С.Дамдинсүрэн: Би С.Дамдинсүрэн гэдэг хүн.

Байгаль орчин, уур амьсгалын сайдын зөвлөлийн гишүүн, Монголын ан агнуурын холбооны удирдах зөвлөлийн гишүүн хүн байгаа юм.

Би хоёрдугаар асуудлаар саналаа хэлье. Дуудлага худалдаатай холбоотой асуудлаар.

Ер нь тухайн үед 2023 онд нэг том эндүүрэл болоод permit conservation auction буюу хамгааллын дуудлага худалдаа гэж Америкт болдог. Тэрийг андуураад манай зарим Хассуурийн Ганхуяг маань, дээр нь тухайн үеийн сайд, хэд хэдэн улсууд тухайн үед яг тэр асуудлаар нэлээн тийм лобби бүлэг үүсэхэд нөлөөлсөн байдаг юм.

Ингээд ерөөсөө энэ дуудлага худалдааг оруулсан. Тэгээд ховор амьтдаа арилжааны дуудлага худалдаанд оруулсан улс ерөөсөө Монгол орон болчихоод байгаа юм. Тийм.

Тэгэхээр үүнийг маш хурдан л засахгүй бол бид CITES-аас анхааруулга авсан байгаа.

Дээр нь ихэнх анчид Америкаас ирдэг учраас Америк руу оруулдаг тропын асуудлыг 2 жилийн өмнө хаасан. Нэг хэсэг хаагаад. Тэгээд манайхан очиж байж бүр Fish and Wildlife гээд Америкийн зэрлэг амьтан цагдаагийн алба байгаа. Экологийн цагдаагийн албаныхантай уулзаж байж нэг юм сэргээгээд, тэгээд бүх тропын олдворууд гарах жишээний.

Тэгэхээр хамгийн эцсийн үүний сөрөг үр дагавар бол ингэж байгаад CITES хоёр дахь удаагаа анхааруулгаа өгөөд л Fish and Wildlife дээр нь дэмжвэл Монголын ан агнуур ингээд хаагдана. Нэг хаагдсан ан агнуурыг 5-аас 10 жилдээ бараг нээдэггүй. Одоо тийм гашуун туршлагатай.

Тийм учраас хамгийн гол нь ан хаагдвал нөгөө амьтан эзэнгүй болно. Нөгөө дуудлагаар ордог олон их мөнгөтэй авч байсан нөхдүүд чинь одоо эргээд амьтан дээр авчхаад л ангаа агначхаад л явчхаад, арынх нь мониторинг, судалгаа, менежмент хариуцагчийн бүх зардлуудыг гаргахгүй явчхаж байгаа улс чинь одоо ан хамгаалагдах амьтан байхгүй болоод хэдэн мэргэжлийн ангийн байгууллагууд ангаа авч чадахгүй болсон учраас мөнгө байхгүй.

Ингээд үндсэндээ төрийн өмч хэлбэртэйгээр хуучин шатандаа эргэж очоод ингээд эзэнгүйдэх нэг ийм л их аюул нүүрлэж байгаа юм. Үүнийг л би хэлэх гэсэн юм.

Тэгээд энэ дээр нэг ингэсэн шүү. Энэ 2024 он, 2025 он хоёрт нөгөө дуудлагад оруулсан лоббигийн нөхдүүд чинь бас нөлөөлөөд нэмэлт тогтоол гаргуулсан. Засгийн газраар. 26 дугаар тогтоолыг 2024 онд гаргуулсан, 242 дугаар тогтоолын 2 дахь хавсралт буюу соёлын зориулалтаар гээд 20, 20 угалз, 20, 20 янгирын тэх нэмж гаргуулсан. Сайдад нөлөөлж байгаад, Засгийн газарт нөлөөлж байгаад ингээд Засгийн газрын тогтоол гаргуулсан.

Тэгэнгүүт гадаадын байгууллагууд, CITES бүр нүд нь орой дээрээ гараад Fish and Wildlife энэ тэр. Тэгээд тэр дотор COP17... /минут дуусав/

Н.Батсүмбэрэл: Баярлалаа. Танд. Эхний асуудлыг хэлэлцэж дууслаа.

Бидэнд монголын аялал жуулчлалын салбарт тулгамдаж байгаа асуудал, шийдэл, Монголын талаар мэдээлэл өгсөн холбооны нөхдүүдэд баярлалаа.

Энэ мэдээлэлтэй холбоотойгоор үг хэлэх гишүүн байна уу? Р.Батболд гишүүн үг хэлэх үү? Р.Батболд гишүүний микрофоныг нээе.

Р.Батболд: Яах вэ, одоо мэргэжлийн холбооныхон маань яг миний яриад байдаг зүйлийг л яриад байна л даа. Бас л нөгөө жуулчны баазуудыг яаж юутай байршуулах юм. Тийм ээ. Би нөгөө Тэрэлжийг л жишээ болгоод яриад байгаа. Ам болгон, жалга болгоны эрэг дээр ингээд хоёр талд нь л аваачаад жуулчны бааз байгуулдаг. Тэгээд бүгдээрээ дампуурах гээд байдаг. Дампуурах гэхээрээ л үнээ нэмээд байдаг. Тэгээд л баахан үнэтэй.

Дотоодод аялснаас илүү гадаадад аялсан нь хямдхан болчихоод байна шүү дээ гэдэг л юм руу яваад байгаа байхгүй юу.

Тэгэхээр үүнийг яамныхан маань. Би эртнээс л яриад байгаа. Үүнийг бас нэг төлөвлөөд дахин төлөвлөх арга байдаг юм уу, байдаггүй юм уу. Тэрэлжээр чинь дүүрэн л газрууд боллоо. Зарим нь ч нурж унасан, зарим нь гайгүй үйлчилгээтэй ингээд яваад байдаг.

Тэгээд бүгдээрээ бие биеийгээ дагаад үнээ нэмсээр байтал энэ чинь монгол хүн очиж амрах аргагүй боллоо шүү дээ. Ер нь сүүлдээ.

Нэг өдрийн нэг гэрт гэдэг юм уу, юу гэдэг юм, 500, 600 мянган төгрөгөөр хоноод амраад байх дотоодын жуулчин хэр байгаа юм бэ? Тийм ээ. Дотоод, гадаадаа ялгаж эсвэл харьцах юм уу, яаж явах ёстой юм. Энэ дээр бас нэг бодлого гаргах хэрэгтэй байх.

Яах вэ, болоод байна гэж бодоод бид ингээд явуулаад байж болох байх. Эцэст нь нэг ам болгонд нурж унасан юм уу, урагдсан хэдэн гэртэй нэг нэг байшингууд л үлдэж л таарах байх. Аялал жуулчлал маань өөрөө.

Тэгэхээр энэ дээр бас нэг жоохон бодлогын хэмжээний юм гаргахгүй бол арай болохгүй байна гэдэг санал яваад байдаг юм.

Хоёрдугаарт, саяын яриад байгаа тэр антай холбоотой асуудлыг сайн авч үзэхгүй бол үүнийг Байгаль орчны яамтай цуг үзмээр юм шиг байгаа юм. Тэгэхгүй бол ойлголтын зөрүүгээсээ болоод бид яах вэ, дотооддоо нэг их мундаг авлига, янз янзын юмнуудыг нь хаагаад. Хаагаад яваад байгаа юм шиг мөртлөө улсдаа хортой юм хийх гээд байгаа байхгүй юу. Өөрсдөө. Тийм ээ. Хортой юм хийгээд байна л даа. Нөгөө ордог байсан төсвүүд нь сумандаа очихгүй болохоор яах юм.

Тэгээд отог байгуулаад аятайхан явж байсан зүйлүүд нь өөрсдөө алдагдаад ирэхээр энэ чинь байгаль хамгаалал, бүртгэл тоон дээрээ хүртэл.

Тэгээд сая яг нэг ноцтой хэдэн нэг зүйл хэлэх гэж байх шиг байлаа.

Тэгээд цаг нь дуусаад болих шиг боллоо. Засгийн газар дээр чинь янз бүрийн тогтоолууд гараад, соёлын шугамаар энэ тэр гэж гараад Байгаль орчны яамнаас тэр COP-ийн төлөөлөгчдөд зориулна ч гэлүү, нэг тийм бүр Байгаль орчны яамнаас гараад ан агнуулах тийм юу гарсан байгаа байхгүй юу.

Тэр COP17-той холбоотой ан агнуулна гэж юу гэсэн ч үг юм. Цөлжилтийн эсрэг конвенцтой холбоотой ан агнуулна гээд. Тийм хүртэл тушаал гараад явж байдаг ийм бүр замбараагүй юм руу ороод байгаа юм. Үүнийг нэг жоохон цэгцэд нь оруулах тал дээр л ажиллах хэрэгтэй юм шиг байгаа юм. Тийм.

Н.Батсүмбэрэл: Р.Батболд гишүүнд баярлалаа. Мэдээлэл хийсэн холбооны хүмүүс, төлөөлөгч нартаа баярлалаа.

Тэгээд надаас хэд хэдэн санал байна.

Нэгдүгээрт, энэ холбоо маань сая танилцуулсан танилцуулгыг нэлээн сайн танилцуулга бэлдсэн байна. Төлөөлж ирсэн хүмүүс маань. Индэрт микрофонд үгээ хэлцгээлээ.

Тэгэхээр Та бүхэн энэ холбооныхоо албан бланк дээр дэд хорооны нэр дээр бичгээ даруй ирүүлмээр байна.

Өнөөдрийн танилцуулсан мэдээллүүдээсээ тусгасан асуудлаа. Мөн Та бүхэн өөрсдийн ярьж танилцуулсан асуудлуудаараа. Тэр дотроо тэр хөндсөн хуулийн өөрчлөлтийн асуудал, аялал жуулчлалын хөгжлийн асуудал, ан агнуурын асуудлуудаар нэг бичиг байж болно. Тухайлаад тус тусад нь бичиг байж болно.

Тэгээд Та бүхэн бичгээ хэдий хурдан өгөхөөс хамаарч бид дараагийн арга хэмжээнүүдээ авна. Үүнийг Та бүхэнд сонордуулъя.

Тэгээд өнөөдрийн мэдээллээс улбаалаад аялал жуулчлалын хөгжлийн дэд хорооны дараагийн хурлаар Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын мэдээллийг яг энэ ан агнуурын асуудлаар сонсьё. Үүнийг манай ажлын алба тэмдэглэлдээ оруулаарай.

Өмнө нь ярьсан хуулийн асуудлаар Аялал жуулчлалын сайдын, мэргэжлийн сайдын байр суурийг сонсьё.

Холбооноос ирсэн бичгийг үндэслээд агнуурын асуудлаар албан ёсоор холбогдох яамдаас бид мэдээллийг авч холбогдох арга хэмжээг авч ажиллая.

Р.Батболд гишүүн энэ талаар нэлээн сайн өргөн мэдээлэлтэй учраас манай холбооны нөхдүүд Р.Батболд гишүүнтэй ажил хэргийн шугамаар холбогдоод мэдээллээ сайн танилцуулж болох нь байна.

Ингээд нэгдүгээр асуудлыг хэлэлцэж дууслаа. Танилцуулга хийсэн Та бүхэндээ баярлалаа. Ажлын хэсэг гарч ирж болно.

Дараагийн хоёрдугаар асуудалдаа орьё.

Хоёрдугаар асуудлыг Р.Батболд гишүүний микрофоныг нээе.

Р.Батболд: Яах вэ, ингэмээр байгаа юм. Одоо ирэх хурлаар чинь бид зөвхөн Байгаль орчны яам биш Аялал жуулчлалынхаа яамтай цуг сууж байгаад ярьмаар байна.

Саяын ан агнууртай холбоотой энэ асуудлаа яг яаж цэгцэд нь оруулаад хэн нь. Байгаль орчны яам л хариуцаад явах байх л даа. Тэгэхдээ Аялал жуулчлалын яам маань өөрсдөө саналаа өгөөд ингэж явмаар юм байна гэдэг тал дээр нь, яг зэрэгцэж сууж байгаад ярихгүй бол нэг нэг яам нь ирээд яриад байхаар хоорондоо сүүлдээ ойлголцохгүй зөрчилдөөд яв болов уу гэсэн нэг тийм зүйл байгаа шүү. Тийм.

Н.Батсүмбэрэл: Байгаль орчны яамны танилцуулга дээр тэгээд Аялал жуулчлалын яамнаас ижил түвшний албан тушаалтан ирээд хуралд оролцоод мэдээллээ солилцоод явъя. Тэгж тэмдэглэл дээр шийдье. Баярлалаа. Та бүхэнд.

Хоёрдугаар асуудал руугаа орьё.

**Хоёр.Аялал жуулчлалын салбарыг
дэмжихэд чиглэсэн хөнгөлөлттэй зээлийн талаарх
Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын
сайдын мэдээллийг сонсох**

Хоёрдугаар асуудал. Аялал жуулчлалын салбарыг дэмжихэд чиглэсэн хөнгөлөлттэй зээлийн талаарх Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын мэдээллийг сонсоно. Танилцуулгыг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газрын дарга В.Батчимэг танилцуулна.

В.Батчимэг: Сайн байцаана уу?

Аялал жуулчлалын хөгжлийн дэд хорооны эрхэм гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Өмнөх аялал жуулчлалын хөгжлийн дэд хорооны хуралдаан дээр явцын танилцуулгыг хийсэн.

Тэрнээс хойших мэдээллүүдийг танилцуулах нь зөв байх гээд товч тодорхой мэдээллийг хүргэе.

Энэ хугацаанд өмнөх хуралдаанаас гарсан чиглэлийн дагуу ажлууд маань явагдаж байгаа. Хил орчмын аялал жуулчлалын асуудлаар маргааш бусад оролцогч яамдын бүрэлдэхүүний хамтаар Дорноговь аймаг болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Эрээн хотод ажиллахаар төлөвлөсөн байгаа.

Тэгээд энэ Аялал жуулчлалын хөгжлийн дэд хорооны гишүүд, удирдлагуудад баярласнаа илэрхийлье. Бидний уулзалтын хүрээнд ажлууд маань эрчимтэй авч явж байгаа гэдгийг илэрхийлье.

Аялал жуулчлалын салбарыг дэмжих хөнгөлөлттэй зээлийн явцын танилцуулгыг танилцуулъя.

2026 онд 250 тэрбум төгрөгийн зээлийн асуудал шийдэгдсэн байгаа. Үүний хүрээнд зарласантай холбогдуулаад арилжааны 10 банканд 2 их наяд төгрөг давсан хүсэлтүүд ирсэн байгаа. Үүний дагуу банкуудад 2 их наяд төгрөгөөс эхний 400 тэрбум төгрөгийг судалж үзэж байгаа юм байна. 198 аж ахуйн 404 тэрбум төгрөгийн зээлийн хүсэлтийг арилжааны 10 банканд эхний байдлаар авч үзэж байгаа.

Үүнээс манай яам нь буюу 500 саяас дээш хяналтын гэрээ байгуулах ёстой байгаа. Гэрээ нь ерөнхий гэрээгээр тусгагдсан. Эхний 15 аж ахуйн нэгж судлагдаж байна. Нийт манай Соёл, спорт, аялал жуулчлалын яаман дээр 28 аж ахуйн хяналтын гэрээ хийх хүсэлт ирсэн. Үүнээс 15 нь судлагдаж байна. 13 нь хяналтын гэрээ байгуулагдаад явж байна.

Ер нь бид олон нийтэд маш нээлттэй хандаж байгаа. 13 аж ахуйн нэгжийн хуваарилалтыг харах юм бол 6 сегмент дээр гаргаж байгаа. Зочид буудал дээр гэхэд аж ахуйн нэгж 7 байх жишээтэй. Жуулчны бааз дээр 3, аялал жуулчлалын цогцолбор 4, зам дагуух түр буудлага цэг 2 гээд нийт 28 аж ахуйн нэгжийн хүсэлт ирүүлсэн дээр 13 дээр нь хяналтын гэрээ байгуулсан.

13 хяналтын гэрээ байгуулсан аж ахуйн нэгжүүдийг бид салбарын аж ахуйн нэгж мөн үү гэдэг судалгаан дээр бид ажилласан. 2 аж ахуйн нэгж шинээр орж ирж байгаа.

Нэг нь шинэ зочид буудал барихаар. Нөгөөх нь зам дагуух түр буудлага цэг гэсэн.

Бусад аж ахуйн нэгжүүд нь дандаа манай аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа тогтмол хийж хэрэгжүүлсэн аж ахуйн нэгжийн жагсаалт гарсан байгаа.

Одоогоор 250 тэрбум төгрөгийн 86 тэрбум төгрөг дээр шийдвэр гарсан явж байгаа. Үүнээс яг гар дээр олгогдсон нь 12 аж ахуйн нэгжийн 5 тэрбум 993 сая төгрөг олгогдсон байх нь.

Одоогийн байдлаар ийм явж байгаа. 42 аж ахуйн нэгжийн 86 тэрбум төгрөгийн зээл олгох шийдвэр гарсан байгаа. Үүнээс яг гар дээр олгогдсон нь 5 тэрбум 900 байгаа. Бусад юунууд нь манай дээр хяналтын гэрээ хийлгэгдэхээр судлагдаад явж байгаа.

Мөн өмнөх долоо хоногт банкуудтай Соёл, спорт, аялал жуулчлалын сайд, Монголбанкны Ерөнхийлөгч С.Наранцогт, Сангийн яамны удирдлагууд, мөн арилжааны 10 банкны удирдлагуудтай уулзалт хийж, зээлийн явцын танилцуулгыг хийгээд, ярилцаад, уулзалтаас 3 шийдвэр гарсан.

Ямар шийдвэр гарсан бэ гэхээр Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар хяналт шалгалт хийх ажлын хэсэг байгуулж ажиллахаар болсон.

Зээлийн санхүүжилтийн ерөнхий гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулья Жишээлэх юм бол 7 тэрбум хүртэлх зээл олголт байгаа. Тэрийг 2 хүртэлх ч байдаг юм уу. Тийм ээ. Аль болох хүртээмжтэй байлгая гэдэг дээр бид бас ийм шийдвэрийг гаргасан.

Хяналтын гэрээ байгуулсан болон зээл авч байгаа аж ахуйн нэгжүүдийн мэдээллийг нээлттэй, ил тод мэдээлэх ийм 3 шийдвэр гарсан.

Шийдвэрийн дагуу бид өчигдөр Монголбанканд удирдлагуудтай уулзаж ажлын хэсгийн бүрэлдэхүүнд нэрсийг хүргүүлсэн. Өмнөх хуралдаан дээр оролцсон мэргэжлийн холбоодын төлөөллүүдээс оролцуулж, хяналт шалгалтын ажлын хэсгийг байгуулахаар болсон.

Хяналт шалгалт хийх хугацаанд зээлийг түр зогсоох шийдвэр бас гарч байгаа.

Тэгэхээр одоо гарсан 86 тэрбумыгаа явдгаар нь яваад, үлдсэн дээрээ бид түр зогсолт хийгээд зээлийн шалгаруулалтдаа нэмэлт, өөрчлөлтийг хийгээд явъя гэдэг шийдвэрийг гаргасан байгаа.

Асуух асуулт байвал хариулья.

Н.Батсүмбэрэл: Болсон уу?

В.Батчимэг: Болсон.

Н.Батсүмбэрэл: Баярлалаа. Асуулт асуух гишүүд нэрээ өгье.

Л.Соронзонболд гишүүний микрофоныг нээе.

Л.Соронзонболд: Аялал жуулчлалын салбарт олгож байгаа энэ зээлийн нөхцөлийг ялангуяа хөдөө орон нутагт аялал жуулчлалын бизнес эрхэлж байгаа компани, аж ахуйн нэгж, иргэд бол маш их сонирхож байгаа юм.

Тэгээд энэ зээлийн олголт дээр яг тухайн орон нутгаас ирж байгаа хүсэлтүүдийнх нь тоо, тэгээд тэндээс нь шалгарсан байгаа аж ахуйн нэгж, иргэдийн зээлдэгчийнх нь тоо нь хэд байгаа юм бэ? Энэ талаар нэг мэдээлэл байвал өгөөч ээ.

Н.Батсүмбэрэл: Индрийн микрофон нээе.

В.Батчимэг: Дэлгэц дээр гаргая. Бид бүхэн мэдээлэлтэй танилцуулга дээр гарсан байгаа.

Ер нь аймаг, орон нутгууд дээр...

Н.Батсүмбэрэл: В.Батчимэг дарга түр байгаарай. Презентэйшнийг дэлгэц дээр өгье.

4 дэх слайд дээр. Наадах чинь байна. Тийм ээ. В.Батчимэг дарга үргэлжлүүлье.

В.Батчимэг: Одоо судлагдаж байгаа 250 тэрбум дээр нийтдээ 2 их наядын хүсэлт ирсэн байгаа.

Яг одоо 10 арилжааны банкн дээр 198 зээлдэгчийг 404 тэрбум төгрөгийн зээл судлагдаж байгаа. Үүн дээр аймаг, орон нутгуудаар ангилж харах юм бол ийм явагдаж байгаа.

Дараагийнх дээр нь нэлээдгүй тодорхой байгаа. Тийм ээ.

Архангай аймагт 1 байна. Булганд 1, Дорноговь аймагт 1 гээд нийт 28 аж ахуйн нэгжийн хяналтын гэрээ хийхээр ирсэн байгаа. Манай яаман дээр.

Улаанбаатарт	11,
Сэлэнгэд	1,
Төв аймагт	1,
Эрдэнэтэд	1,
Хэнтий аймагт	1,
Хөвсгөл	3,
Өмнөговь	2,
Дорноговь	1 гээд байгаа.

Бид жуулчны баазуудын зээл олголтын асуудал дээр нийслэлд болон орон нутагт гэдгээрээ 45 тэрбум төгрөг хуваарилагдсан байгаа. Жуулчны бааз дээр. Түүнийхээ 20-ийг нь хөдөө орон нутгууд дээр гэдэг хуваарилалтыг Монголбанкнаас хуваарилалтыг банкууд руугаа өгсөн байгаа.

Н.Батсүмбэрэл: Л.Соронзонболд гишүүн тодруулъя.

Л.Соронзонболд: Тэгэхээр 20 тэрбум төгрөгийг хөдөө, орон нутгийн аялал жуулчлалын үйлчилгээ эрхэлж байгаа компаниудад зориулсан гэхээр нэг аймагт ойролцоогоор 1 тэрбум төгрөг гэж төлөвлөөд байна уу, эсвэл сая өргөдлийн хүсэлтийг харахаар зарим аймгийн хүсэлт зээл авах гэж байгаа хэмжээнд 3 тэрбум төгрөг ганцаараа. Зарим газар 200 сая төгрөгөөр нэг хүн гээд хуваарилсан байгаа байхгүй юу.

Гэтэл зүүн бүсийн хувьд хараад үзэхээр аялал түүхийн аялал жуулчлалыг гол тэргүүлэх салбар болгоно гээд. Тэгээд энэ чиглэлээр нэлээн ажлууд хийгдээд сурталчилгаа их хийгдсэн.

Тэгээд хүмүүс аягүй их хүлээлттэй. Аялал жуулчлалын яамнаас явж байгаа энэ зээлийн хөтөлбөрт хамрагдана гээд хүсэлтээ өгөөд байдаг. Тэгэнгүүт нэг аймгаас нэгхэн хүнийг 200 сая төгрөгөөр шийдэхээр адилхан бусад аймагт болгож байгаа учраас хамаагүй бага болоод байгаа байхгүй юу.

Тэгээд энэ тал дээр яг яаман дээр тодорхой бодлого байгаа юм уу? Ямар байдлаар эх үүсвэрийг аймаг болгонд хуваарилж байна вэ гэж асуух гэсэн.

Н.Батсүмбэрэл: Индрийн микрофон нээе.

В.Батчимэг: Л.Соронзонболд гишүүний асуултад хариулъя.

Мэдээж бид аймаг, орон нутгууддаа хүртээмжтэйгээр жуулчдыг аль болох аймаг, орон нутаг руугаа аялах боломжийг нэмэгдүүлэх хүрээнд бид бодлого барьж байгаа.

Гэсэн хэдий ч бид энэ зээлийн гэрээг гуравласан гурван оролцогч талууд буюу мөнгөний хуваарилалтыг Монголбанк хийж байгаа. Төв банк маань хийж байгаа.

Бид энэ дээр яг тэр аймагт тэдийг өг гэдэг дээр санал өгөөгүй байгаа. Нээлттэй, хүртээмжтэй байдлаар. Энэхүү зээл маань ер нь цаашдаа 6 жилийн хугацаанд үргэлжилж явах учраас энэ жилийн зээлийн маань хүртээмж яалт ч үгүй 250 тэрбум байгаа.

Салбарын хүрээнд маш их хүлээлттэй, аймаг, орон нутгууд авахыг маш их хүсэж байгаа. Бид сая энэ зээлийн асуудалтай өмнөх долоо хоногт аймаг, орон нутгууд болон зээл дээр ирсэн хүсэлтийг... /минут дуусав/

Н.Батсүмбэрэл: Үргэлжлүүлж хариу хэлье. Микрофоныг нь нээе.

В.Батчимэг: Судалгаа хийж ажилласан. Үүн дээр аймаг, орон нутгууд дээр далан хэдэн хувь буюу хамгийн ихээр аймаг, орон нутгууд дээр зээл авах хүсэлттэй байгааг бид судалгаанаас харсан.

Энэ судалгаагаа бид Монголбанканд, Төв банканд хүргүүлсэн байгаа.

Н.Батсүмбэрэл: Р.Батболд гишүүн асуултаа асууя.

Р.Батболд: В.Батчимэг дарга аа, би нөгөөдхөө л дахиад ярих гээд байгаа юм.

Одоо бид зээл өгөөд байна шүү дээ. Тэгээд нөгөө аймгуудад хүлээлт үүссэн. Ингээд авмаар байна. 200 сая төгрөг гээд яриад байна.

Тэгэхээр аймгуудын бодлого нь ямар байгаа юм бэ гэдэг л асуудал байгаа байхгүй юу. Одоо аль бүс нутаг гэдэг юм уу, аль хэсэгтээ бид яг энэ аялал жуулчлалаа хөгжүүлээд явъя.

Түүнээс биш нэг айлын гадаа байгаа. Бид чинь нөгөө өрхүүдийг дэмжээд ингээд нэг жуулчин авдаг больё гээд л гаднаа хоёр сайхан гэр барьчих. Түүнд чинь жуулчин явуулъя гээд байгаа биш шүү дээ. Энэ чинь. Тийм ээ. Арай өөр зорилготой гэж ойлгоод байгаа юм.

Тэгэхээр тэр бодлогынхоо хүрээнд л явмаар байгаа байхгүй юу. Аймгуудад хуваарилж байна гэж байгаа бол тэр аймгууд нь ямар санал ирүүлээд байгаа юм? Аль хэсгийнхээ, аль сумынхаа, аль байгалийн цогцолбор газрыг хөгжүүлье гээд байгаа юм. Түүн дээрээ бид зээл авъя гэдэг санал нь ирсэн юм уу, ирээгүй юм уу юм уу гэдгийг сайн үзэх хэрэгтэй. Тэгж байж бид энэ зээлээ үр ашигтай болгох хэрэгтэй байгаа юм.

Түүнээс биш зүгээр нөгөө л хэлдэг нэг уулын аманд аваачиж бид 5 гэр барьдаг. Тэрийгээ аялал жуулчлал хөгжүүлэх гээд байгаа юм гээд байдаг. Нөгөөх нь үйлчлүүлэгч байхгүй бол дампуураад унадаг. Нэг ийм байдалтай явах юм бол энэ зээл маань ч хэрэггүй, бид бодлогогүй л яваад байгаагийн нэг илрэл болох байх.

Хоёрдугаарт гэх юм бол, яах вэ, банканд дээр 7-гоос доошоо 2 хүртэл болгож байгаа юм байна шүү дээ. Монголбанк тийм болгож байгаа юм байна. Тийм ээ. Яах вэ, хүртээмжээ бодоод тэгж байгаа байх гээд бодъё.

Зүгээр нөгөө талаасаа банкны энэ хувь эзэмшигч нартай хамаарал бүхий гэдэг юм уу, тийм ээ, ийм аж ахуйн нэгжүүд чинь бас орж ирээд тийм аваад байх вий. Энэ дээр нэг анхаарлаа хандуулаарай.

Одоо манай Монголын банк чинь бүх юм руу ордог боллоо. Тийм ээ. Бүр хоол хүртэл хийгээд байна. Энэ жуулчин хамгийн нэлээн дээгүүртээ орж явах байлгүй.

Тэгэхээр энэ дээр нэг анхаарч ажиллаарай гээд хэлмээр байна. Тэгэхгүй бол банкууд чинь хамаарал бүхий аж ахуйн нэгжүүддээ хамаг зээлийг чинь тараагаад өгөх вий гэдэг ийм зүйл дээр анхаараарай гэж хэлмээр байна.

Н.Батсүмбэрэл: Индрийн микрофоныг нээе.

В.Батчимэг: Манай Монгол Улсын аялал жуулчлалын голлох маршрут яалт ч үгүй Хөвсгөл, говийн бүс. Сүүлийн жилүүдэд 2024 оноос эхлээд зүүн аймгийг түүхэн аялал жуулчлалын бүс болгож зарласан. Баруун Алтай таван богд руу гээд чиглэлтэй аяллууд явж байгаа.

Ер нь Хөвсгөл, говийн бүс рүү дийлэнх 25 хувиас дээш аяллууд явж байгаа.

Бид мэдээж энэ чиглэл рүү төлөвлөлтүүдийг хийж байгаа.

Дээр нь, улсын аялал жуулчлалын бүс байгуулагдсан, батлагдсан. Улсын аялал жуулчлалынхаа бүс дээр бид аймаг, орон нутгуудтайгаа түшиглээд аймаг, орон нутагтай хамтраад төлөлтүүдийг хийгээд, төлөлтийнхөө дагуу олон улсын зээлийн бодлого, хөнгөлөлттэй зээлийн бодлогоор хөгжүүлэлтүүдийг хийе гэсэн бодлоготой байгаа.

Таны тэр шалгуур үзүүлэлт дээр бид сая өмнөх долоо хоногт Монголбанк болон бусад банкны төлөөлөлтэй уулзсаны дагуу бид шалгуур үзүүлэлтээ дахиж өөрчилье гэсэн. Энэ дээр та бүгдийн энэ дэвшүүлж байгаа саналыг шалгуур үзүүлэлт дээрээ дахиад нэмж өөрчлөх саналыг бид өөрчлөлтөд оруулъя гэж бодож байна.

Тэгээд хяналтын гэрээг авсан 13 аж ахуйн нэгж болон үлдсэн 15 дээрээ бид аялал жуулчлалын яг үйл ажиллагаа эрхэлдэг нь мөн үү гэдэг дээр манай Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газрынхан бүгд ажиллаж байгаа.

Ер нь яг одоогоор авсан газар маань 12-хон газар буюу 5 тэрбум төгрөгийн зээл олгогдсон байгаа. Тэр нь дандаа аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүд байгаа. Дийлэнх нь орон нут нутгийн аж ахуйн нэгжүүд байсан. Архангай аймаг гээд авсан аймаг, орон нутгууд дээр тэгш хүртээмжтэй олголт хийгдэж байгаа.

Мэдээж бидний хамгийн голлох зах зээл буюу Хөвсгөл аймаг дээр арай илүү байх жишээтэй. Тийм ээ.

Тэгэхээр ийм нээлттэйгээр бид олон нийтэд танилцуулж ажиллаж байгаа гэдгээ илэрхийлье.

Н.Батсүмбэрэл: Р.Батболд гишүүн тодруулж асууя.

Р.Батболд: Яах вэ, би асуулт байхгүй. Дахиад нөгөөдхөө л хэлэх гээд байгаа юм. Бид сая 4 бүс гэж хэлээд байна шүү дээ. Говийн бүс байна. Хойшоо Хөвсгөл байна. Тэгээд Алтай таван богд. Зүүн бүсийг аялал жуулчлалын бүс гээд зарласан.

Ядаж эд нар луугаа явж байгаа газар дээрээ бид зам дээр 100 километр тутам гэдэг юм уу, 50 километр тутам гэдэг юм уу нэг амрах цэгтэй, нолийг нь шийдэх. Энэ тал руугаа л хамгийн гол нь чиглүүлж өгөөсэй гэж би бодоод байгаа юм.

Тэгээд зүүн бүсийн тэр нэг дуусаагүй байгаа тэр Дадал гээд газруудаар дуусаагүй байгаа цогцолборууд байна шүү дээ. Эд нарыгаа маш хурдан дуусгамаар байна.

Тэгээд бодлогоороо хэчнээн бааз яаж яаж байх юм бэ. Тийм ээ. Аль аль аманд нь хэдийг өгөх юм бэ гэдгээ та хэд нэг сайн гаргаад тэрнийхээ дагуу яваарай л гэж хэлэх гээд байгаа юм.

Ер нь Дадалд түрүү жил очиход баазууд баригдаад байгаа байхгүй юу.

Тэгэхээр тэрийг Тэрэлж шиг болгох юм бол муухай болно шүү. Тийм ээ.

Н.Батсүмбэрэл: Тодруулж хариулах уу? Болсон уу? Индрийн микрофон нээе.

В.Батчимэг: Р.Батболд гишүүний асуултад хариулья.

Тэгээд бид бүгд түрүүн хэлсэнчлэн улсын аялал жуулчлалын бүсийг хийж байсныхаа дагуу яг энэ таны хэлж байгаагаар тэр 10 километр тутамдаа баазууд байх юм уу, ойр орчимд нь оршин суугчдын бүсийг байлгахгүй байх. Мэдээж Тэрэлж орчим, Хөвсгөл орчим шиг ийм байдлуудыг дахиж үүсгэхгүйн төлөө л бид улсын аялал жуулчлалын бүсийг батлуулсан байгаа.

Тэгээд Та бүгдийн саналыг хүлээж авч тусгаж ажиллахаа илэрхийлье. Баярлалаа.

Н.Батсүмбэрэл: Би нэг асуулт асуугаадахъя. В.Батчимэг дарга.

Энэ гишүүдийн болон олон нийтээс ирээд байгаа саналууд байгаа.

Нэгдүгээрт, энэ гарч байгаа зээлүүд дээр компани өөрийнхөө компанийн эзэн байна шүү дээ. Хувь эзэмшигч. Эзэмшигч өөрийнхөө хамааралтай компанид зээл өгч байгаа байдлыг хянаж байгаа юу? Ийм үйлдэл гарч байгаа юу?

Сая гишүүдийн яриад байгаа тэр олон салбарт үйл ажиллагаа явуулдаг болчихоод байдаг нэг эзэнтэй банк, компаниуд гээд. Энэ дээр хяналт тавьж байгаа юу гэдгийг асууя. Ийм юм гарсан уу? Энэ дээр хяналт тавьж байгаа юу?

Хоёрдугаарт нь, энэ зээл чинь өмнө нь огт олгоогүй. Тийм ээ. В.Батчимэг дарга аа, өмнө нь зээл олгосон уу, энэ чинь эхнийх билүү гэдэг дээр асууя.

Гурав дахь нь, бид ингээд бүсчилсэн хөгжил яриад байгаа тохиолдолд бүсүүдэд тодорхой квотууд зааж өгч болох уу? Мөнгөө хуваарилж цаашдаа. Энэ гурван асуулт дээр хариулт авъя.

В.Батчимэг: Ер нь одоогоор 13 аж ахуйн нэгж ирсэн. Энэ дээр ямар нэгэн банкны хамааралтай аж ахуйн нэгжийн юу ирээгүй. 2 шинэ аж ахуйн нэгж гарсан. Энэ маань болохоор нэг нь зам дагуух түр буудлах цэг. Нэг нь спортын цогцолбортой газар зочид буудал нэмэгдүүлж барих гэдэг хоёх асуудал ирсэн. Бусад нь дан аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аймаг, орон нутгуудын аж ахуйн нэгжүүдэд шийдвэр гарсан байгаа.

Мэдээж бид аль болох хүртээмжтэй байлгахыг барьж байгаа учраас нэг аж ахуйн нэгжид хоёр, гурван төрөл дээр олохгүй байя гэдэг бодлогыг барьж ажиллаж байгаа.

Энэ нэрс нь надад байгаа. Түрүүн танилцуулга өмнөх юун дээр ирүүлсэн байгаа. Тэрийг Т.Билэг-Өрнөх өө, тараах уу. Тийм ээ. Гишүүдэд өгөх үү. Энэ вордын файлууд байгаа шүү дээ. Тийм. Ирж байгаа. Тийм.

Тэгэхээр 13 аж ахуйн нэгжийн нэрс бүгд бэлэн бидэнд байгаа. Үүнийг бид олон нийтэд нээлттэй зарлаж байгаа.

Одоо бид шалгуураа өөрчилж байгаа. Түүн дээр Н.Батсүмбэрэл дарга аа, энэ 4 бүс дээрээ квотлоод, дээр нь Р.Батболд гишүүний хэлсэн зам дагуу түр буудаллах цэгүүдээ нарийвчилж оруулах гээд энэ асуудлуудыг шалгуур үзүүлэлт дээрээ дахиад тусгая.

Н.Батсүмбэрэл: Гишүүд асуулт асууж дууслаа. /алх цохив/

Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү? Л.Соронзонболд гишүүнээр тасаллаа.

Л.Соронзонболд гишүүний микрофоныг нээе.

Л.Соронзонболд: Энэ аялал жуулчлалыг дэмжих энэ хөнгөлөлттэй зээлийн асуудал миний сайн мэдэхийн бараг 3, 4 жил болж байгаа асуудал. Тэгээд энэ жилээс эхэлж байгаа юм байна.

Тэгээд эхлээд явж байгаад зогсож байгаа гэж сонслоо.

Тэгэхээр аялал жуулчлал хариуцаж байгаа яам маань өөрөө энэ дээр бодлогоо гаргаж аягүй тийм идэвхтэй, санаачилгатай ажиллахгүй бол мэдээж банкны салбарынхан бол аль болох эрсдэлээ бодно. Үүнтэй холбоотойгоор тодорхой хязгаарлалтууд хийгдсэн юм байгаа юм байна гэж би харж байгаа.

Тийм учраас ялангуяа жишээлбэл зүүн бүс байлаа гэхэд Дорнод аймагт байна, Хэнтий аймагт байна, Сүхбаатар аймагт байна. Яг ямар аялал жуулчлалын хэлбэр нь илүү хөгжих боломжтой байгаа юм. Аль юун дээр нь илүү дэмжих юм. Тэрийгээ тодорхой гаргаад. Энэ жилийн хувьд жишээлбэл ийм чиглэлийн, аялал жуулчлалын бааз байгуулах чиглэлээр нь. Спорт аялал жуулчлалын чиглэлийг нь дэмжих. Эсвэл хүүхдийн зуслангийн чиглэлийг нь дэмжих ч гэдэг юм уу. Ингээд тодорхой яг хэрэгжих боломжтой юмнуудыг нь гаргаад тэр чиглэл рүү нь бодлогоо гаргаж чиглүүлж явахгүй бол зарим нэг нь ингээд л 5 тэрбум төгрөгөөр зээл авдаг. Зарим нь 1 тэрбумыг авах гээд байгаа мөртлөө 200 саяар зээл авдаг гээд ийм ялгаатай байдал цаашдаа үүсэж болохгүй байх гэж бодож байна.

Тийм учраас энэ Аялал жуулчлалын яам маань өөрөө бодлогоо гаргаад аймаг, орон нутгийнхаа тэр аялал жуулчлалын холбоо, ирж байгаа хүсэлтүүд, аймаг, орон нутгуудын тавьж байгаа тэргүүлэх байршлууд, чиглэлүүдийг нь харж байгаад энэ дээрээ нэлээн чиглүүлэх дээр нь сайн анхаарахгүй бол болохгүй байх гэж бодож байна.

Тэгээд түрүүн гишүүд ярилаа. Н.Батсүмбэрэл дарга ирж байна. Р.Батболд гишүүн ярьж байна. Тэр яг аялал жуулчлалаар дамжуулж тухайн орон нутагт амьдарч ажиллаж байгаа хүмүүсийг аялал жуулчлалын салбараар энэ бодлогын зээлээрээ дэмжих тал дээр анхаараарай гэж хэлмээр байгаа юм.

Тэгэхгүй илүү нэлээн боломжийн болсон, үйл ажиллагаа нь тогтворжсон компаниуд аялал жуулчлалын салбар луу орохыг буруутгаагүй. Гэхдээ энэ аялал жуулчлалын чиглэлийг чинь гол нь тухайн орон нутагтаа ажиллаж амьдардаг. Энэ чинь ерөөсөө 2-оос 3 сарын хугацаанд л үйлчилгээ болоод л явах гээд байгаа бизнес шүү дээ.

Тэгэхээр энэ боломжийг нь тэр орон нутагтаа үйл ажиллагаа явуулахаар санаар ажлаа гаргаж байгаа аж ахуйн нэгж, иргэдийг дэмжих дээр анхаараарай. Ялангуяа бодлогын хувьд энэ дээр тодорхой хувь тавьж ажиллах нь зөв байх гэж санал хэлмээр байна.

Н.Батсүмбэрэл: Хуралд оролцсон гишүүддээ баярлалаа.

Тэгээд дараагийн хурлаар ангийн асуудал ярихаар болж байна.

Тэгээд Р.Батболд гишүүн, Т.Билэг-Өрнөх ажлын албаны даргатай ярьж байгаад мэдээллээ нэлээн сайн саналаа томъёоллоо боловсруулах нь зөв байна.

Бидний ажилд идэвхтэй шуурхай ажилд хандаж байгаа Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны хамт олонд талархал илэрхийлье. Үүнийг Та сайд болон холбогдох хүмүүстээ уламжилж хэлээрэй.

Мөн дэд хорооноос гаргасан саналыг Хууль зүйн яам, Зам, тээврийн яам нэлээн ажил хэрэгчээр хандаж энэ дээр ажлын хэсэг гаргаж зарим хурлууд дээрээ ярилцаж, холбогдох шийдвэрийг гаргаж, маргааш зарим аймгуудаар ажиллах юм байна.

Мөн холбогдох зарим яамдаас мэдээллүүд ирэхээр хүлээгдэж байна.

Тэгээд бид саяын ярьсан зээлийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, зээлийг ил тод болгох, зээлийн хүртээмжийг бодитойгоор нэмэгдүүлэхийн тулд бүсчүүдэд квот олгох гээд асуудлуудыг анхаарч ажиллахыг захъя.

Мөн зээлийн эх үүсвэр нэмэгдүүлэх, зээлийг ил тод болохтой холбоотойгоор сан байгуулах. Түүнтэй холбоотой Их Хурлын шийдвэр гаргах асуудал хөндөгдсөн. Үүнийгээ мэргэжлийн яам бидэнд саналаа гаргаад өгвөл бид үүнийг Их Хурлын гишүүдийн түвшинд өргөн бариад саналаа шуурхай шийдээд явах бололцоотой байна.

Ингээд өнөөдрийн хурал дууссаныг мэдэгдье. Баярлалаа Та бүхэнд. /алх цохив/

Хуралдаан 1 цаг 07 минут үргэлжилж, 11 цаг 25 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД